

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн 4 дүгээр хавсралт

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТЫН 2025 ОНЫ ТАЙЛАН

Орхон аймаг

2025.12.25-ны өдөр

Тайлант хугацаанд нийт 374 сургалт, семинар, зөвлөгөөн зохион байгуулснаас 49,5%-ийг ажлын байран дахь сургалт 8,5%-ийг мэргэшүүлэх сургалт 7,2%-ийг туршлага солилцох арга хэмжээ эзэлж байгаа бөгөөд давхардсан тоогоор 3496 албан хаагч хамрагдсанаас удирдах албан тушаалтан 15,2%, гүйцэтгэх, туслах, албан тушаалтан 92,2%-ийг эзэлж байна. Нийт төрийн албан хаагч 586 ажиллаж байгаагаас сургалтад хамрагдсан нийт албан хаагчдад эзлэх хувь 100% байна. Сургалт, семинар, зөвлөгөөний тоо өмнөх оноос 6,8%-иар, хамрагдсан нийт албан хаагчдын тоо 12,7%-иар нэмэгдсэн байна.

№	Сургалтын сэдэв	Тайлбар	Хамрагдсан хүний тоо	Сургалтын тоо
1	Төрийн сангийн санхүүжилтээр үндсэн болон төрөлжсөн, мэргэжил дээшлүүлэх сургалтад эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулах	Өвдөгний үений мэс засал судлал 1, Эмэгтэйчүүдийн хавдар судлал 1, Ходоод, нарийн гэдэсний хавдрын мэс засал судлал 1, Хөх, улаан хоолойн хавдрын мэс засал судлал 1, Эмэгтэйчүүдийн хавдрын мэс засал судлал 1, эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал судлал 1, хавдрын сувилагч 1, хөнгөвчлөх эмчилгээний сувилагч 1, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг судлал 1 Төрөлжсөн мэргэшлийн сургалтад 12 их эмч хамрагдсан. Үүнд: цээж, хэвлийн гэмтлийн мэс засал судлал 1, цус судлал 1, хүүхдийн мэдээгүйжүүлэг 1, хавдрын хими эмчилгээ судлал 1, эпидемиологи 1, эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт 1, уушги судал 1, хадварын ангиографи 1, хүүхдийн дүрс оношилгоо судлал 1, яаралтай тусламж судлал 1, дотоод шүүрэл судлал 1, нойр булчирхайн хавдрын мэс засал 1 Мэргэжил дээшлүүлэх сургалтад 9 их эмч, Үүнд: Нүүр амны гажиг судлал 2, Гэмтэл согог судлал 1, Мэдрэл судлал 1, Хүүхэд судлал 2, Анатомийн эмгэг судлал 1, Зүү эмчилгээ судлал 1, Дүрс оношилгоо судлал 1, хавдар судлал 1 Сувилахуйн болон эмнэлэгийн бусад мэргэжилтнийг мэргэшүүлэх сургалтад нийт 1 сувилагч хамрагдсан. Үүнд: гэмтэл согогийн сувилахуй Төрийн албаны дунд шатны сургалтад 1 төрийн захиргааны мэргэжилтэн суралцаж байна. Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалтад суралцаж төгссөн байна.	9	9
2	Удирдлагын академи, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад хамруулах	ТАЗ-аас зохион байгуулсан "ТАХ-ын ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ" хэлэлцүүлэг, "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал бүсийн зөвлөгөөн"-д 11 албан хаагч хамрагдсан. Удирдлагын академиас зохион байгуулдаг 7 хоног бүрийн пүрэв гарагийн 7:4:10 цахим сургалтад давхардсан тоогоор 212 төрийн албан хаагч хамрагдсан.	12	12
			10	8
			1	1
			1	1
			1	1
			11	1
			126	1

	Удирдлагын академиас зохион байгуулсан "Монгол улсын хөгжлийн бодлого, хэрэгжилт" сэтгэлгээний өөрчлөлт сургалтад 3 албан хаагч хамрагдсан сертификат авсан.	3	1
	Удирдлагын академийн Эмнэлгийн менежер мэргэшүүлэх сургалтад 1 албан хаагч суралцаж байна.	1	1
	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн чиглэлээр нийт 16 удаагийн соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулсан бөгөөд 1647 эмч, мэргэжилтнийг хамруулсан. Үүнээс төрийн албан хаагч 587 хамрагдсан байна.	587	16
	АШУҮИС-ын нийгмийн эрүүл мэндийн сургуультай хамтран "эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй" сэдэвт 2 багц цагийн сургалтыг зохион байгуулж 18 эрүүл мэндийн байгууллагуудын 186 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.	186	1
3	“Амьдралын зөв хараа” НҮТББ-тай хамтран “Еннеаграм ба Урлагийн сэтгэл засал”, “Хувь хүний хөгжил” сэтгэл зүйн сургалтыг Эрүүл мэндийн газрын 33 албан хаагчдад хамрагдаж чадавхжсан.	33	1
	Ёс зүйн академитай хамтарсан “Ёс зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх багц” сургалтад ЭМГ-ын 24 албан хаагч, БОЭТ-ийн 75 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж чадавхжсан.	99	1
	ЭМГ, БОЭТ, Жаргалант сумын ёс зүйн хороодын гишүүдийг чадавхжуулах 2 удаагийн танхимын сургалтад 25 албан хаагч хамрагдсан	25	2
	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар ЭМГ, БОЭТ, СӨЭМТ-үүдийн захиргааны ажилтнуудад сургалт зохион байгуулж нийт 21 төрийн албан хаагч хамрагдсан.	21	3
4	Хууль, эрх зүйн сургалт зохион байгуулах	141	3
	Эрүүл мэндийн газрын Авлигын эсрэг 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилт, 8 арга хэмжээний хүрээнд батлуулсан. Авлигатай тэмцэх газрын цахим системд олон нийтэд ил тод болгохоор заасан мэдээллээс эрүүл мэндийн салбарын ажилчид болон эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдэд хамаарагдах 1 зурган постер, 2 богино хэмжээний бичлэгийг Орхон аймгийн Эрүүл мэндийн газар цахим системд нээлттэй байршуулж нийт 5621 хүн үзсэн байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 129, Жаргалант сумын өрхийн эрүүл мэндийн төвийн 12, нийт 141 амч, сувилагч, эрүүл мэндийн ажилтнуудад Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг таниулах, ойлголтыг нэмэгдүүлэх сургалтыг хамтран зохион байгуулсан. Тайлант хугацаанд Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 6 эрх бүхий албан тушаалтан хуулийн хугацаанд мэдүүлсэн. Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй албан хаагч байхгүй. Төлөвлөгөөний хэрэгжилт 91%-тай байна.		
5	ХАБЭА-н сургалт зохион байгуулах	75	3
	Хөдөлөр халамж үйлчилгээ газар, Эрдэнэт дээд сургуулийн хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтан хамтран нийт ажилчдын дунд ХАБЭА-н сургалтыг 75 ажилтанд зохион байгуулсан.		

6	Эмнэлзүйн болон халдварын сэргийлэлт сургалт	ЭМЯ, ЭМХТ, ХӨСҮТ, ЭХЭМҮТ мэргэжлийн салбар зөвлөлөөс зохион байгуулсан Улаанбаатар хот болон бусад хот, аймгуудад зохион байгуулагдсан 49 удаагийн сургалтанд 501 эмч эмнэлгийн ажилтан хамрагдсан.	501	49
7	Ажлын байран дахь сургалтыг зохион байгуулах	Ажлын байран дахь 112 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 2075 төрийн албан хаагч хамрагдсан. Үүнд: халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар эрсдэл, халдварын сэргийлэлт хяналт, томуу, томуу төст өвчний талаар авах арга хэмжээ, эмийн зохистой хэрэглээ, эмнэлгийн аюултай хог хаягдал, яаралтай тусламж, дархлаажуулалт, эх хүүхэд нөхөн үржихүй, уламжлалт анагаах ухаан, сэргээн засах бусад эмч эмнэлгийн мэргэжилтэнг чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулсан байна.	2075	112
5	Гадаад сургалт, семинар зохион байгуулах	2025 онд эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд Япон, Узбекистан, БНХАУ, БНСУ, Филиппин, Малайз, Киргиз, АНУ зэрэг улсуудад зохион байгуулагдсан нийт 15 удаагийн сургалт, семинарт 35 эмч эх барих эмэгтэйчүүд, нярай, нүд, бөөр, гэмтэл согог, зүрх судас, мэс засал, эрүүл мэндийн удирдлага зэрэг чиглэлээр амжилттай оролцсон. Эдгээр сургалт, чуулганууд нь онол-дадлага хосолсон, дэвшилтэт технологи, орчин үеийн эмчилгээний арга барил, олон улсын туршлагыг судлах өндөр ач холбогдолтой байлаа. Тодруулбал дутуу нярайн эрчимт эмчилгээ, жирэмсний хэт авиан оношилгоо, бөөр болон мэс заслын шинэ чиг хандлагын талаар гүнзгий мэдлэг олж авсан. Мөн Солонгосын их сургуулийн эмнэлгүүдэд ажлын байрны болон урт хугацааны төрөлжсөн сургалтад хамрагдаж, сертификат авсан эмч нар мэс заслын практик ур чадвараа дээшлүүлсэн. Үүний зэрэгцээ эрүүл мэндийн аялал жуулчлал, олон улсын хамтын ажиллагаа, туршлага солилцоог өргөжүүлэх чухал үр дүнд хүрсэн.	35	15
9	Сургалт, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, сэтгүүл хэвлүүлэх	Эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр 2025 онд хэдэн хэдэн ажлыг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. тухайлбал: - Эмч нарын дунд зохион байгуулсан эрдэм шинжилгээний бага хуралд 13 байгууллагын 134 эмч судлаач нарын 34, Сувилагч, тусгай мэргэжилтний дунд зохион байгуулсан эрдэм шинжилгээний бага хуралд 9 байгууллагын 65 судлаач сувилагчийн 15 илтгэлийг хэлэлцүүлсэн. - БОЭТ-ийн захирлын 2025.05.21-ний өдрийн А/46 тоот тушаалаар "Тусгай захиалгат эрдэм шинжилгээ, судалгааны л ажлын тэргүүлэх чиглэлийг баталсан. - АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуультай хамтран Судалгааны арга зүйн чиглэлээр үечилсэн сургалтанд судлаач эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээ хамруулан чадвахуулсан байна. Энэ онд тус төвөөс ЭШХ-ыг "СУДЛААЧ-2025" уриан дор нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх, дэвшилтэт технологийн ололт амжилтыг оновчтой нэвтрүүлэх, ТҮ-	274	3

		г чанартай, аюулгүй, хүртээмжтэй үзүүлэх зорилгоор зохион байгууллаа. Хуралд нийт 18 тасгийн 27 судлаач эмч нарын нийт 9 илтгэл, 48 судлаач сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн 13 илтгэл нийт 22 илтгэлийг хэлэлцэж шилдэг бүтээлүүдийг тодрууллаа. Зочин илтгэлийг "Үүдэл эсийн эмчилгээний эрин Монголд" сэдвээр Анагаах ухааны доктор Ph.D, дэд профессор Э.Одхүү танилцуулсан. Эмч нарын илтгэлүүдээс: Тэргүүн байр: "Эх нярайн эрүүл мэндийн дэлхийн флатформ судалгааны дүн", Дэд байр: "Баракамер эмчилгээний үр дүнг судалсан нь", Гутгаар байр: "Орхон аймагт өвдөгний дурангийн мэс заслын практик хэрэглээний өнөөгийн байдал", Тусгай байр: "Бүлэн хайлуулах эмчилгээний үр дүн", Сувилагч тусгай мэргэжилтнүүдийн илтгэлүүдээс Тэргүүн байр: "Тохойн хугарлын гэмтлийн дараах сэргээн засах эмчилгээний үр дүнг судлах нь", Дэд байр: "Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх үеийн эмч сувилагчийн хамтын оролцоо" Гутгаар байр: "Сувилагч тусгай мэргэжилтнүүдийн сэтгэл хөдлөлөө удирдах чадвар нь үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж байгааг судлах нь", Тусгай байр: "Сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилтний аюулгүй байдлыг түвшинг үнэлсэн нь" сэдэвт бүтээл тус тус шалгарлаа. АШУИС-ийн НЭМС-тай хамтарсан судалгааны хийх мэдээллийг шинжлэх арга зүй үечилсэн сургалтуудыг зохион байгуулснаар судлаач нарын судалгааны ажлын арга зүй, боловсруулалт, үр дүнгээ илтгэх байдалд зэрэг нь сайжирсан байна. Мөн 2016 оноос эхлэн "Анагаах увидас" эрдэм шинжилгээний сэтгүүлийг эрхлэн гаргасан бөгөөд энэ онд 9 дэх дугаараа орон нутагт судсан дотуурх оношилгоо, эмчилгээний 1000 дахь тохиолдол хийгдсэн, төвлөрөл сааруулах үндэсний баг орон нутагт ажилласан, хавдрын төвтэй болсонтой холбогдуулан энэ чиглэлийн бүтээлүүдийг багтаасан 16 илтгэл судалгааг хэвлэн нийтийн хүртээл болгосон ба улмаар мэргэжлийн бусад сэтгүүлийн жишигт хүргэх, бүтээлийг туурвисан хэлбэрээр ангилан төрөлжүүлэх, дараагийн судлаач нарт гарын авлага болгох, тулгамдсан асуудлыг судлан, шийдвэрлэх арга замыг хайх зорилгоор өргөжүүлэн хөгжүүлэсээр байна.		
10	Туршлага солилцох арга хэмжээ	Эрүүл мэндийн чиглэлээр бодлого, шийдвэр, хууль эрхзүйн хэрэгжилтийг хангуулах, мэргэжил аргазүйгээр ханган ажиллаж байгаа ЭМБ-уудын удирдлага, албан хаагчдыг туршлага солилцох, чадавхжуулах уулзалт хийж Эрүүл мэндийн яам болон Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагаатай ЭМГ-ын дарга, ахлах мэргэжилтэнгүүд, мэргэжилтэн нийт 20 мэргэжилтэн танилцлаа.	20	1

	Өрхийн эрүүл мэндийн төвийн 8 эх баригчийг ажлын 5 өдөр БОЭТ-ийн өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйчүүдийн кабинетэд сэлгэн ажиллуулж ажлын байран дээр дадлагажуулан чадавхжуулсан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төрөх тасгийн 21 сувилагчийг Эх нярайн үндэсний төв II-ийн төрөх тасагт ажлын 2 хоног туршлага судлуулан дадлагажуулсан байна. БОЭТ-ийн төрөх тасаг Нийслэлийн Өргөө амаржих газрын "Эмэгтэйчүүдийн мэс засал"-ын тасагтай хамтран Орхон аймагт анх удаа хэвлийн дурангаар умайг бүхэлд нь авах мэс засал хийсэн. Хэвлийн дурангаар TLN хагалаа 2 тохиолдол хийсэн. Хүндрэлгүй. БОЭТ, ЭХЭМҮТ-тэй хамтран нярайн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байранд чадавхжуулах, сэлгэн ажиллуулах хүрээнд БОЭТ-ийн нярайн тасгийн 4 эмч тус бүр 7 хоногоор, 3 сувилагчийг ажлын 2 өдрөөр ЭХЭМҮТ-ийн дутуу нярайн тасаг, эрчимт эмчилгээний тасагт дадлагажуулан дутуу болон хэт бага жинтэй нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний ур чадварыг нэмэгдүүлэн, туршлага судлуулан ажиллуулж, чадавхжуулсан.		21	1
			2	1
			7	1
	Мэргэшүүлэх сургалт		34	32
Нийт дотоод гадаад сургалт	Ажлын байран дахь сургалт		2075	112
	Туршлага судлах		58	50
	Бусад		1329	180
	Нийт		3496 Давхардсан тоогоор	374
	Гадаад сургалт		35	15

Боловсруулсан:

Хүний нөөцийн төлөвлөлт хангалт, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн

М.Бямбасүрэн

Хянасан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн

П.Хишгээ